



310

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар A/194

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 274 дүгээр зүйлийн 274.4 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөнхий газар /бригадын генерал Ц.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх өрөнхий газрын даргын 2004 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн A/41 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



С.БЯМБАЦОГТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын иргэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад анх томилогдохдоо “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг” /цаашид “Тангараг” гэх/ өргөнө.

1.2. Тангараг нь алба хаагчдаас хууль болон хүний эрхийг дээдэлж, байгууллага, хувь хүний нууцыг хадгалан, алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахиж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад чин шударгаар зүтгэхээ илэрхийлж буй амлалт, андгай юм.

1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг /цаашид “Ёслолын ажиллагаа” гэх/ зохион байгуулахдаа энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Тангараг өргөх ёслолын ажиллагааны зохион байгуулалт

2.1. Тангараг өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын тушаалаар батлах ба энэхүү тушаалыг үндэслэн орон нутагт дахь хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын дарга нар өөрсдийн тушаалаар зохион байгуулж болно.

Тушаалд ёслолын ажиллагааг зохион байгуулах албан тушаалтан, газар, хугацаа (өдөр, цаг)-г зааж өгнө.

2.2. Ёслолын ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон нэгж (алба хаагч) журамд заасны дагуу зохион байгуулна.

2.3. Ёслолын ажиллагаа зохион байгуулах газар (байр)-ыг тусгайлан сонгож, бэлтгэл ажлыг хангах бөгөөд тэнд Монгол Улсын Төрийн сүлд, далбаа, байгууллагын түгийг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

2.4. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд тангараг өргөх алба хаагч /цаашид “Тангараг өргөгч” гэх/, түүнийг шууд захирах дарга буюу байгууллагын бусад алба хаагчид оролцох ба төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, иргэдийг оролцуулж болно.

2.5. Тангараг өргөгч нь тогтоосон цаг хугацаанд ёслолын ажиллагаа зохион байгуулах газар (байр)-т ёслолын дүрэмт хувцастай ирж, Монгол Улсын Төрийн сүлд рүү эгц харан жагсана.

2.6. Ёслолын ажиллагааг энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан тушаалаар томилогдсон албан тушаалтан удирдана.

2.7. Ёслолын ажиллагаа удирдаж буй албан тушаалтан тангараг өргөх бэлтгэл бүрэн хангагдсан болохыг удирдах даргад илтгэж, тангараг өргүүлэх тухай тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулснаар ёслолын ажиллагаа эхлэнэ.

2.8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шинээр томилогдсон алба хаагч нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг”-ийг “Төрийн жинхэнэ алба хаагчийн тангараг”-ийн хамт өргөнө.

2.9. Тангарагийг ганцаар болон хамтаар өргөж болох бөгөөд хамтаар өргөх үед насаар хамгийн ахмад алба хаагч “Төрийн жинхэнэ алба хаагчийн тангараг”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг”-ийг тус тус цээжээр дээдлэн дуудаж бусад нь дагалдана. Тангараг өргөж байх үед ёслолын ажиллагаанд оролцогчид босч хүндэтгэл үзүүлнэ.

2.10. Алба хаагч тангараг өргөж дуусмагц тангарагийн хуудсанд гарын үсэг зурж, төрийн далбаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тугийн өмнө малгайгаа зүүн гар дээрээ барьж, баруун өвдөг дээрээ сөгдөн адис авсны дараа малгайгаа өмсэн ёслон хүндэтгэж жагсаалд орно.

2.11. Ёслолын ажиллагаа удирдаж буй албан тушаалтан тангараг өргөсөн бие бүрэлдэхүүнд баяр хүргэх ба алба хаагчдаас гурван удаа “Ура” цуурайтуулсны дараа төрийн дуулал эгшиглүүлэн, дагаж дуулснаар ёслолын ажиллагааг хаана.

Гурав. Бусад

3.1. Ёслолын ажиллагааг баярын болон тэмдэглэлт өдөр, түүхэн ойг тохиолдуулан зохион байгуулж болно.

3.2. Ёслолын ажиллагааг тохиолдуулан ёслол хүндэтгэл (урлаг, спортын болон бусад)-ийн арга хэмжээг зохион байгуулж болно.

3.3. Тангаргийн хуудсанд “Төрийн жинхэнэ алба хаагчийн тангараг”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг”, огноо, газар, алба хаагчийн овог, нэр, цол, томилогдсон нэгж, гарын үсэг байна.

3.4. Тангаргийн хуудас нь алба хаагч гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарснаар баталгаажих бөгөөд түүнийг алба хаагчийн хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн, бусад байгууллагад шилжин ажилласан иргэн дахин томилогдсон тохиолдолд тангараг өргөхгүй байж болно.

3.6. Ёслолын ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно.

---оОо---